

**СУРАХ БИЧГИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА,
АРГА ЗҮЙН БОЛОМЖУУД**

Д.Цэвээндорж

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд ЕБС-ийн сурах бичгийн чанарыг сайжруулах шаардлагыг хөтөлбөр (цөм)-ийн шинэчлэл ба хэрэгжилт, өмнө хэвлэгдсэн зарим нэг сурах бичгийн хэл найруулга, боловсруулалтын алдаан дээр тулгуурлан дэвшүүлжээ. Мөн дэлхий нийтийн дунд сургуулийн сурах бичгийн ололт- шинэчлэл, бүтээлч санаачлагуудыг мөрдлөгө болгож, сурах бичигт тавигдах олон улсын шаардлага, хэмжүүрийг туршиж хэрэгжүүлэхийн чухлыг онцлон авч үзжээ. Түүнчлэн чанарын түвшинг нэмэгдүүлэх боломж (зохиогчийн болон редакторын баг) хийгээд шинэ санаачлага (сурагчийн ном, дадлагын баг) дэвшүүлэхдээ олон улсад хэрэгжүүлж буй сургалтыг оновчтой хөтлөх онол-арга зүйн дэвшилтэт боломж, аргуудаас орчуулан танилцуулж санал, дүгнэлтээ боловсруулжээ.

Түлхүүр үгс: *Сурах бичиг, хүүхдийн нас-сэтгэхүйн онцлог, эх хэлний боловсрол, бие хүний төлөвшил, сурган хүмүүжүүлэх онол, зорилго, хэл найруулгын алдаа, шинэ санаачлага нэвтрүүлэх*

Удиртгал

Эх хэлний боловсрол нь аливаа боловсрол, мэдлэгийн үндэс суурь юм. Эх хэлний боловсролыг системтэй, цэгцтэй олж авахад сайн хөтөч-багш, өгөөжтэй ном, сонирхолтой танин мэдэхүйн хэрэглэгдэхүүн зэрэг олон хүчин зүйл чухаг нөлөөтэй ч албан ёсны мэдлэгийн эх сурвалж болох ЕБС-ийн сурах бичгийн үүргийг гүнзгий ухамсарлаж сайтар боловсруулах нь чухал хэвээр байна. Судлаачдын тогтоосноор ангид хичээллэж буй сурагчдын 98 хувь нь багшаас бус сургалтын хэрэглэгдэхүүнээс зааварчилгаа авч байсан бол гэрийн даалгаврын 90 хувийг мөн сурах бичиг, номоос авч (Jackson, 1981) байжээ.

Эх хэлний мэдлэгийн суурь сайн тавигдвал хэлэх өгүүлэхүйн чадвар, бичиж найруулах эрдэмд багаасаа боловсрох үүд илүүтэй нээгдэхийн зэрэгцээ бүтээлч сэтгэлгээ, өөртөө итгэх чадамж, бие даасан чадвар, тэсвэр хатуужил гэх мэт хувь хүнээс бие хүн болж төлөвших үндсэн зарчмуудыг гүн бат эзэмших боломжтой юм. Харамсалтай нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн утга соёл төдийгүй хэл найруулгын боловсрол, түвшин эдүгээг хүртэл хангалтгүй хэвээр буй нь сэтгүүлчдийн туршлага, чадамж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн илүүдэл төдийгүй сурагчдын ерөнхий мэдлэг, сурах бичигт хандах хандлагад хүртэл сөргөөр нөлөөлж буйг тэмдэглэхгүй өнгөрөх аргагүй байна. БСШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт болон Их дээд сургуулийн мэргэжлийн багш нар нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэдтэй анх удаа нэгдэж сурах

бичгийн агуулга, арга зүйг шинэчлэх, олон улсын түвшинд ойртуулах хүрээнд хамтран ажиллах болсон нь сургалтын үр дүн, хүртээмж рүү дөхсөн том дэвшил юм. Өөрөөр хэлэхэд өмнөх сурах бичгүүд цөөн (4-5) тооны асуулт даалгавраас бүрдэж байсан бол 2017 оноос хойших шинэ сурах бичгүүд сурагчдын хэрэглээнд суурилсан олон төрлийн дасгал, суралцахуйн зорилтоос бүрдсэн онцлогтой юм. Гэхдээ энэ нь уншигчдыг залхаах, хуудас, талбайн зай хэмжээг нэмэгдүүлэх (үндсэн агуулга буюу эх зохиолоос хасагдаж), бие даан сэтгэн бодох чадварт нөлөөлөх, сурагчдын бүтээлч хамтын ажиллагааг бууруулах зэрэг сөрөг талуудаас зайлсхийх шаардлагад нийцэх ёстой билээ. Учир нь сурах бичгийг: “a book used as a standard work for the study of a particular subject”¹ гэх буюу “textbook is a printed and bound artefact for each year or course of study” (Encyclopedia of Education, 2008) хэмээн ерөнхийлөн тодорхойлдог нь тусгай салбар, шинжлэх ухааны мэдлэгийг олгох үндсэн гарын авлага гэсэн агуулгыг төлөөлдөг.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША, доктор С.Энхжаргал, ЭША Д.Боролзой нар хамтын бүтээлдээ сурах бичгийн үгийн сангийн тоог гаргасан нь бидний судалгаанд үнэ цэнтэй юм. Тухайлбал зөвхөн “Монгол хэлний сурах бичиг”-ийн хувьд:

№	Сурах бичиг	Үгийн тоо	Зөрүү
1	1-р анги	2600	
2	2-р анги	21000	+18400
3	3-р анги	27500	+6500
4	4-р анги	38000	+10500
5	5-р анги	33000	-5000

гэсэн (Энхжаргал, Боролзой, 2017:28) үзүүлэлттэй байна. Эндээс харахад зөвхөн 1, 2-р анги +18400, 4, 5-р ангийн сурах бичгүүд хоорондоо -5000 үгийн сангийн зөрүүтэй байгаа нь сурах бичиг бүрийн хуудасны тоо бараг ижил, нэг стандарт хэмжээтэй ч агуулгын шатлал, нас сэтгэхүйд тохирсон боловсруулалт буюу уялдаа холбоогүйг илтгэж байна. Гагц сурах бичигт бус суралцагсдын оюун санаан дахь үгийн санг жигд нэмэгдүүлж ёс суртахуун, сэтгэлгээний өндөр чадамжтай, хүнлэг иргэн болгон төлөвшүүлэх нь ЕБС-ийн үндсэн зорилтын нэг мөн. Түүнчлэн 6 настнууд ихэвчлэн нэр, үйл үгс, тэмдэг нэр, төлөөний үгээр ярьж үгийн утгыг шууд утгаар нь ойлгож дунджаар 2600 үгийг илэрхийлдэг (үгийн сангийн нөөцтэй) ч 20000-24000 үгийг хүлээн авч ойлгодог² зэрэг тооцоо судалгааг цаашид анги бүрт харгалзан үзэх нь боловсрол судлалын мэргэжилтнүүд, сурах бичиг зохиогчдын багийнханд анхаарвал зохилтой шаардлагын нэг юм.

Нэг. Алдаа санамжууд

Салбар бүрийн сурах бичгүүд шинжлэх ухааны үндэслэлтэй, сүүлийн үеийн судалгаанд түшиглэсэн үнэн зөв, баттай, цэгцтэй мэдлэгийг түгээх нь зүйтэй юм. Ялангуяа нэг ойлголт, ухагдахууныг янз бүрээр тайлбарладаг байж боломгүй байна. Тухайлбал “Эрүүл мэнд” сурах бичигт “сэтгэц эрүүл хүн”, “сэтгэцийн хувьд эрүүл бус хүн” (Мөнгөнтулга нар, 2014:26) гэсэн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёог хэрэглэж буй нь өрнөдийн анагаах ухааны үг хэллэгийг үгчилж орчуулсны гэм бөгөөд “mental sound”-ийг “Сэтгэцийн эмгэг (өвчин)” гэсэн үгээр төлөөлүүлэх тогтсон ойлголт бийг энэхүү сурах бичгийг бэлтгэсэн багийн гишүүд үл хайхарчээ. Мөн “хүнсний бүтээгдэхүүнд ажиглагдах шимт бодис, ...шим тэжээлийн бодис”, “уушиг, уушги” зэрэг үг хэллэг, ойлголтыг зөрүүтэй бичсэн нь ажиглагддаг. Тухайлбал “цэцгээс, цэцэгнээс” гэх буюу 167-р талд “Би цэцэгнээс хамгийн сайхан нь” гэж бичсэн

¹ <https://www.oxforddictionaries.com/definition/textbook>.

² https://www.superduperinc.com/handouts/pdf/149_VocabularyDevelopment.pdf

атлаа удаах хуудсанд “цэцгээс хэсэглэн авч” (Оюунцэцэг нар, 2017:168) зэрэг үг үсэг, хэл найруулгын алдаа, нэг үгийг тухайн сурах бичигт хоёр өөрөөр бичсэн хариуцлагагүй байдал цөөнгүй ажиглагдаж байна. Энэ нь “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага” MNS5418:2008 стандартын 5.4.1 дэх “танин мэдэхүйн тухайн түвшинд тохирсон хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй, найруулга нь зөв оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, эмх цэгцтэй байна” гэж заасныг зөрчсөнийх юм. “Цагаан тал гэж юу байж болох уу?”, “Ямар ямар үр мэдэх үү?”, “Тэр үрийг цагаан талдаа суулгасан, суулгана гэж яахыг хэлэх үү?” (Бямбацэрэн нар, 2018:53), “Цасан дээр мөр гаргахаар ямар сэтгэгдэл төрдөг үү?” (Бямбацэрэн нар, 2018:54) гэсэн асуултууд нь ярианы хэлэнд дулдуйдсан маш хариуцлагагүй алдаанд тооцогдох бөгөөд эдгээр асуух өгүүлбэрүүдийг бүхэлд нь “вэ?” гэсэн сул үг, асуух нөхцлөөр төгсгөн хэлбэржүүлэх байв.

“Зохиолч Ж.Дашдондогийн “Цэнхэр салхи” шүлэгт *хуйлран салхилж байгаа зургийг* хоёр настай Сүнжий усан будгаар зурсан юм” (Цэдэн-Иш нар, 2017:58) гэсэн нь 2-р ангийн сурагчдад атугай тодорхойгүй найруулга юм. Угтаа зургийг хараад шүлэг төрсөн атал 2 настай охин нь аавынхаа шүлгийг уншиж юм уу сонсож ойлгоод зураг зурчихсан мэт ойлгогдохоор бичжээ. Мөн “Дараа нь хаана байрлуулахаа төлөвлөн арчилгааг *тогтмолжуулаарай* (Батчулуун нар, 2018:55), “...дүрсүүдээ ангилж *дугуйд дугаарыг бичээрэй*” (Эрдэнэчимэг, Энхчимэг, 2018:15) зэргийг “тогтмол арчлаарай”, “дүрсүүдээ ангилж дугуй дүрсэн дотор дугаарыг бичээрэй” гэж дараалуулсан бол монгол хэлний зөв бүтэц бүхий найруулгын хэв маяг болох билээ. Энэ мэтээр орчуулгын зохиол мэт үгийн сонголт, өгүүлбэрийн зохион байгуулалт цөөнгүй ажээ. Улмаар “эхлэх, эхэлсэн, туслах, тусалцаа, судлах, судалцаа” гэх мэт үгийн хувилалыг үл анзаарч зөрүүтэй бичдэг нь зөв бичгийн дүрмийг ягштал баримталж “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (2008), “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018) зэрэгтэй тулгаж үзээгүйн дутагдлыг илтгэдэг. Тиймээс “Цөөрөм рүү уначхаж гэнэ” (Туяа нар, 2016:10), “Хурууныхаа өндгийг будаганд дүрж эсвэл будаад цаасанд дарж дүрс үүсгэнэ” (Цэдэн-Иш нар, 2017:6), “Онъсогот гарсан агар зандан мод гэж юуг хэлсэн бэ?” (Батчулуун нар, 2018:44), “Бидний нөхөрлөл 10 жилийн дараа ямар байх бэ?” (Цэндсүрэн нар, 2016:63) гэх мэт зөв бичгийн дүрэм, үг үсэг, цэг таслал, хэл найруулгын алдаа зэрэг нь сурагчдын эх хэлний боловсролд сөргөөр нөлөөлөхүйц болжээ.

Түүнчлэн тасалгааны ургамлын нэрсийг бүхэлд нь нийлүүлж бичсэн (Судалтод, Хэрээнүд, Нилцэцэг, “Зуунаст”) -ий улмаас “Зуун наст” -ыг хэлзүйн хувьд буруу хэлбэржүүлсэн (Хүн ба орчин, 2018:52) нь хариуцлагагүйн алдаа гэхээсээ зохиогчдын ярианы хэлэнд дулдуйдан бичсэн шинж буюу бичиг үсгийн боловсролын түвшинг нь бас илтгэдэг. Улмаар “зурган диаграмаар илэрхийлээрэй” (Хүн ба орчин, 2018:44) хэмээн бичих буюу бяцхан хүү өлсгөлөн чоныг даган явж бэлтрэгний аманд гараа хийж тээглэсэн ясыг нь авч буй (“Баадай хүү”) бичил өгүүллэг оруулсан нь гадаад үгийн сонголтоос гадна бага ангийн (2-р анги) сурагчдад ахадсан, эх бичвэрийн хувьд зөв сонголт эсэх эргэлзээг төрүүлж байна (Туяа нар, 2016:42). “Монгол хэл -IX” (2013) сурах бичигт “Дэгийн дагуу бичих” гэсэн зөвлөмж бий ч ямар дэг нь тодорхойгүй нь кирилл үсгийн хичээнгүйлэн бичих буюу “тиг” гэсэн үг, утгыг эндүүрч бичсэнийг илтгэдэг. Зүй нь монгол хэл, уран зохиолын сурах бичиг нь хэл найруулга, утга зүйн хувьд бусад сурах бичгүүдэд үлгэр жишээ үзүүлэхийн зэрэгцээ сурагчдын өөрийгөө нээх үе шат, хэл, сэтгэхүйн хөгжилд нь онцгой нөлөө үзүүлдгээрээ ялгардаг онцлогийг санууштай юм. Гэхдээ монгол хэл, уран зохиолын сурах бичгийн багийн гишүүдээс бусад сурах бичгийн зохиогчдод эх хэлээрээ утга төгөлдөр, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон ойлгомжтой найруулан бичих чадвар илүү сул байгааг мэргэжлийн холбогдох байгууллагууд цаашид анхаарах нь зүйтэй санагдана. Хэдий мэргэшсэн, туршлагатай гишүүд боловч тухайн хичээлийн агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлэх чадамж, бичиж найруулах эрдмийн гүйцэтгэл, хянан засварлалт дээр

хариуцлага алдсан бяцхан доголдол тухайн сурах бичгийн чанарыг бүхэлд нь бууруулдагийг зохиогчийн баг бүр анхаарууштай. Түүнээс гадна “төвөд” (төвд, түвд, түвэд), “цээж” (чээж) гэх мэт үгсийг нэг мөр болгон жигдлэх нь гагц зохиогчийн багийн мэргэжлийн ур чадвар бус “Монгол хэлний зөв бичгийн дүрэм”, “Журамласан толь”, “Төрийн хэлний үндэсний зөвлөл” зэрэг байгууллага, дүрэм журам, гадаад хүчин зүйлстэй холбогдож байна. Сүүлийн жилүүдэд олон нийтээр сурах бичгийг шүүмжлэх болсон нь энэ мэт үг үсэг, утга найруулгын мэр сэр доголдолтой холбоотой санамж юм. Нөгөө талаар ерөнхий эрдмийн сурах бичгийн зохиогчдын багийнхан шинжлэх ухааны суурь агуулгыг голлоод үг үсэг, хэл зүй, түүнээс улбаалаад логикийн алдаа гаргасан дутагдал ажиглагддаг.

Хүүхдийн хэл яриа, сэтгэхүйг хөгжүүлэх баялаг уламжлал монголчууд бидэнд бий. Гэвч энэхүү өв сан өнөө цаг үе, ялангуяа сурах бичигт төдийлөн жигдэрч чадалгүй ард нийтээр гадаад хэл, сэтгэлгээнд хэт автаж буй нь “тарвас байхгүй, шийгуа л байна” гэж буй худалдагчийн хариулт энэ бүхний нэгэн тод жишээ болно. Тиймээс ардын үлгэр, домог, оньсого, сургаал үгс, зүйр цэцэн үгс зэргийг түлхүү оруулж мэргэжлийн тусгай багийнхны зохиогчдын багт санал болгосон дээрх мэт аман зохиолын төрөл зүйлүүдээс давтахгүйгээр анги бүрт түлхүү сонгож судлуулах нь зүйтэй байна. Учир нь сургуульд дөнгөж элссэн багачуудын хэл ярианы чадварыг нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй хэл зүгшрүүлэх үгс, түргэн хэллэг тун ховор ажээ. Тухайлбал “Монгол хэл-I” (Оюунцэцэг нар, 2017:94) “Монгол хэл-II” (Бямбацэрэн нар, 2015:89) зэрэг сурах бичигт ёс төдий буюу 1-2 ажиглагдав.

Хоёр. Сайжруулах боломж

Сурах бичгийг сургалтын агуулга, хөтөлбөр, багшийн заах арга зүйн хөтөч байх үндсэн үүргээс гадна сурагчдын бие дааж суралцах сонирхол татам “дотоно найз” талаас нь боловсруулах нь чухал юм. “Багшийн ном” нь ямар сэдвүүдийн хүрээнд хичээлийг судлах вэ гэдгийг багтаасан суралцахуйн зорилтод нийцсэн үндсэн сургалтын гарын авлага байдаг. Үүнд мэргэжлийн судлагчид, тэргүүний эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний туршлага, мэдлэгийг тусгах буюу зөвлөмж авах, ЕБС-ийн багш нараас бүрдсэн “дадлагажуулалтын баг” бий болгон наанадаж нэг жилийн өмнөөс “Багшийн ном”-д тусгагдсан хөтөлбөрийн дагуу зарим хичээлээр сурагчдаас санал асууж үр дүнг баталгаажуулан турших санал дэвшүүлэе.

“Эргэх холбоо” бүхий энэхүү дадлагын баг (training team)-т хөтөлбөрийг биелүүлэгч багш нарыг оруулж, редакторын баг (агуулгын болон техник)-т тухайн чиглэлийн багш, мэргэжилтэн, эрдэмтдээс түлхүү сонгох нь зүйтэй байна. Зохиогчийн багийн гишүүдэд эх зохиолыг сонгох, солих эрх, эх зохиох боломж илүү нээлттэй байх төдийгүй сурах бичгийг бэлтгэх цаг хугацааг илүүтэй олгох нь агуулгын давхардлыг арилгах, анги бүрт ахисан мэдлэгийг системтэй, хүртээмжтэй түгээх боломж нэмэгдэх юм. Энэхүү баг мэргэжлийн өндөр зэрэглэлийн гишүүд буюу их дээд сургуулийн заах арга зүйн багш нар, мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтнуудаас голлон бүрдэх нь агуулгын ноцтой алдаанаас зайлсхийх боломжийг нээгдүүлнэ. Учир нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн эрдэмтэд тухайн зохиогчийн багт үгүйгээс “Эх гэж юу вэ?”, “Үйл явдлын шугам гэж юу болох” гэх мэт онолын ойлголт, нэр томъёог зөв зүйтэй тодорхойлох, ямар онолын бүтээлийг эш болгон барих, хэн нь онолч, хэд нь хуулбарлагч зэргийг ялган салгах наад захын шаардлагуудтай эрхгүй тулгардаг. Сурах бичгийн үгийн тайлбар, ном зүйн жагсаалт зэрэг нь эдгээр хэмжүүрийг бэлхнээ гэрчилдэг бөгөөд ахлах ангид тухайн судлагдагдахууны талаарх эрдэмтдийн үнэлэлт (судлал шүүмж), бие даалтаар унших судалгааны эх хэрэглэгдэхүүнийг хавсаргах шаардлага бас урган гарч ирдэг юм. Учир нь сурагчид өөр өөр орчинд янз бүрийн аргачлал (багшийн заах арга зүй)-аар суралцдаг тул сурах бичиг нь сургалтанд үндсэн хөтөчийн үүрэг гүйцэтгэдэг. Нөгөө талаар сурах бичиг нь зөвхөн багшийн хичээлээ заах агуулгын хэрэглэгдэхүүн төдийгүй суралцагсдын сурах үйлдээ бэлтгэн мэдлэгээ бататгах зорилго бүхий өөрийгөө удирдан чиглүүлэх үүрэгтэй

гарын авлага талаас нь зохион туурвих шаардлага үүтгэгдэж байна.

Нэг ёсондоо чанартай, сайн сурах бичиг нь сурагчдын хамтын ажиллагааг өдөөн идэвхжүүлдэг билээ. Мэдлэгийн хүрээ хязгааргүй тул мэдлэгийг зөвхөн түгээн дамжуулах нь хангалттай үйл явц бус юм. Сурган хүмүүжлэх зорилгыг ямагт санаж боловсрол судлалын онол, арга зүйд илүүтэй нийцүүлэх шаардлага тулгарч байна. Тиймээс,

Сурах бичгийн бичлэгийн арга зүй болон сурган хүмүүжүүлэх онолын хүрээнд:


Үзүүлэнт зарчим - The demonstration principle: (Суралцагчид үзүүлэн ажиглахыг дэмжсэн сурах үйл)

Хэрэглэхүйн зарчим - The application principle: (Суралцагчдыг шинэ мэдлэг хэрэглэхийг дэмжсэн сурах үйл)

Идэвхжүүлэх зарчим - The activation principle: (Суралцагчид нь өмнөх мэдлэг юмуу туршлагаа идэвхижүүлэхийг дэмжсэн сурах үйл)

Нэгтгэх зарчим - The integration principle: (Суралцагчдыг өдөр тутмын амьдралд шинэ мэдлэгээ хэрэгжүүлэн хамтатгахыг дэмжсэн сурах үйл)

Даалгавар голлосон зарчим - The task-centered principle: (Суралцагчдыг дасгал ажил төвтэй сурган хүмүүжүүлэх арга барил эрхлэхийг дэмжсэн сурах үйл) (Ben-Ari etc. 2002) зэргийг бүтээлчээр ашиглах шаардлага үүтгэгдэж байна.



Components of Merrill's First Principles of Instruction³

Сурган хүмүүжүүлэх зорилгын хүрээнд:

1. Мэдлэг: Цээжлэн тогтоох, танин мэдэх, мөн баримтыг сэргээн санах
2. Ойлголт, танин мэдэхүй: Баримт, мэдээллийн утгыг ойлгох
3. Хэрэглээ: Баримтын зохистой хэрэглээ, зааварчилгаа, мөн санал бодлууд
4. Задлан шинжлэл: Бүрэлдэхүүн хэсэг дэх нарийвчилсан мэдээлэл
5. Нэгтгэн дүгнэлт: Нэгдсэн хэсэгт бүхэлд нь шинээр багтаах
6. Үнэлгээ: Мэдээлэл болон санаа бодлын үнэ цэн, ач холбогдлыг ялган салгах

Сурах бичгийн хэл найруулга болон агуулгын зохион байгуулалтын хүрээнд:

1. хялбарчлах (Simplification strategies - enhanced cohesion / coherence),
2. энгийнчлэх (Easyfication strategies - enhancing structure),
3. мэдлэгийг гүйцээн олж авах (Scaffolding - providing domain knowledge)

гэсэн гурван зарчмыг харгалзууштай (Hatch, Mary Jo 2007) юм.

³ http://edutechwiki.unige.ch/en/First_principles_of_instruction

Гурав. Зохиогчийн болон редакторын баг

Зохиогчийн болон хянан засварлагчийн баг аль аль нь мэргэжлийн төдийгүй нэг баг болж ажиллах нэгдсэн санаа, хамтын ажиллагаатай байх нь илүү үр дүнтэй нь туршлагаас ажиглагддаг. Заримдаа БСШУЯ, Боловсролын хүрээлэнгээс томилсон техник редакторууд мэргэжлийн бус, нягт нямбай тогтож уншин сайтар засварлахгүй үг үсэг, цэг таслал төдийхөн засвар ирүүлдэг (зарим нь өөрөө уншиж засдаггүй) нь нууц биш юм. Жишээлэхэд “Дүрслэх урлаг”, “Түмэн бодис”, “Хүн ба орчин” зэрэг сурах бичгүүд хэл зүй, найруулгын алдаатай, өөрийн үгээр бичих чадамж буюу учир шалтгааны дараалал бүхий цэгцтэй найруулан бичих чадвар зарим талдаа дутмаг буй нь хэлний чиглэлийн мэргэжилтнүүдэд ил тод ажиглагддаг. Үүнийг Хэл зохиолын хүрээлэнгээс редакторын багт орж ажилласан гишүүд сайн мэдэх бөгөөд засварласны дараа буюу удаах уншилтад өмнөх засвар хийгдээгүй, өгүүлэмж, бичлэг тодорхой бус хэвээр байдаг нь 1-рт хамтын ажиллагаа сул буйтай, 2-рт эх бэлтгэгчид хариуцлагагүй хандсантай холбогддог. Ер нь бусдын бичсэнийг зассанаас дахин шинээр бичиж өгсөн нь илүү хялбар мэт болохыг мэргэжлийн түвшинд шинжээчээр ажилласан гишүүд мэднэ. Нөгөө талаар зохиогч, редакторуудын аль аль нь өмнөх эх ноорогтойгоо тулгаж засвар орсон эсэхийг нягталж үзэх шаардлагатай байна. Учир нь эх бэлтгэлийн явцад хуудас дүүргэлтээс үүтгэн дасгал даалгавар нэмж хасах, үг өгүүлбэр засварлах тохиолдол цөөнгүй гардаг бөгөөд үүнээс улбаатай зарим засвар (шууд оруулсан) цахим бичвэрт хянагдалгүй, бас хийгдэлгүй (хадгалагдалгүй) орхигдох нь бий. Түүнчлэн бүлгүүдийн агуулга, хэмжээний тэнцвэрт байдлыг нягтлахын зэрэгцээ зохиогчид бүлгээс хэсэглэж бус нэгэн бүлгийг дангаар хариуцаж бичвэл бүлгийн зорилгыг биелүүлэхэд илүү үр дүнтэй байдгийг анхаарууштай. Энэ мэтээр байнгын хариуцлагаар улам чамбайруулж гэмээн зохиогчийн болон хянан нягтлагчийн хамтын үүрэг биелэгдэх учиртай. Иймд


1. Хянан засварлагч (техник редактор)-дыг хэл шинжлэлийн мэргэжилтнээр бүрдүүлэх

2. “Математик”, “Хими”, “Дуу хөгжим”, “Иргэний боловсрол” гэх мэт тухайн салбараас хэл бичгийн өндөр чадвартай гишүүдийг зохиогчийн болон редакторын баг (агуулгын)-т сонгох нь зүйтэй байна. Учир нь “Физик”, “Дүрслэх урлаг” гэх мэт салбар нь мэргэжлийн онцлогоос улбаалан хэл найруулгын хувьд түгээмэл бус (“үүсмэл өнгө”, “будгийн нийлүүр”, “толболон чимэглэх” гэх мэт) үг хэллэг, нэр томъёо хэрэглэдэг нь найруулгын алдаанд орох эрсдэлийг нэмэгдүүлдэг талтай ч “Хэдэн сурагч урлагийн ба биеийн тамирын дугуйлангийн аль алинд нь суралцдаг вэ?” (Эрдэнэчимэг, Энхчимэг, 2018:132) гэж бичсэнийг “хэд нь ... дугуйланд, хэд нь ... дугуйланд суралцдаг вэ?” зэргээр товч, бөгөөд тодорхой, ойлгомж, цэгцтэй найруулан засах боломж бий юм. Нэг ёсондоо алдаа, дутагдлыг олж илрүүлэн засвар ирүүлдэг, тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн шинжээчид сурах бичгийн чанар, чансааг нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй тул хариуцаж буй ажилтнууд хяналт тавих нь зүйтэй болов уу. Учир нь эх бэлтгэлийн явцад эх бичвэр буюу үгийн тал, өгүүлбэрийн зарим хэсгүүдийг зургаар дарж (Туяа нар, 2016:15, 38) харагдахгүй болгосон алдааг гагц хэвлэлийн эх бэлтгэгч бус зохиогч, хянан магадлагчид мөн хүлээх учиртай.

Дөрөв. Шинэ санаачлагыг нэвтрүүлэх

Сургууль, анги танхимын хүрэлцээ бага, заах арга зүй сайтай туршлагатай багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүртээмж хангалтгүй байгаа энэ үед зөвхөн танхимд нүүр тулж суралцах төдийгөөр хязгаарлагдалгүй, алсын буюу зайн сургалтаар хүртээмжтэй сургах, асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх хандлагуудыг хэрэгжүүлэх нь чухал байна. Нийгэм, цаг үетэйгээ уялдаж цахим хэлбэрээр унших боломжуудыг өргөтгөх, үндэсний онцлог шингээсэн хувилбар санал болгох цаг нэгэнт иржээ. Нөгөө талаар улс, үндэстэн бүрийн шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол, сурах бичгийн агуулга, стандартыг харьцуулан судалж монгол үндэстний онцлог бүхий арга зүйн шинэ хөтөлбөр боловсруулан нэвтрүүлэх нь явцуу хүрээнээс гарах, дэлхийн жишигт дөхөх бас нэгэн

алхам юм. Тухайлбал ISD (Instructional systems design), Kemp загварын дагуу зорилтоо тодорхойлон бичих, Блүүмын таксаномын арга зүйн дагуу боловсруулахыг мэргэжилтнүүд зөвлөдөг.



Kemp design model (Jones, Alan. 2005)

Профессор Жосе Пикардо ЕБС-ийн сурах бичигт тавигдах шаардлагыг олон улсын түвшинд:

- “Шинэ сэдэв танилцуулах
- Тохирсон зураг, үзүүлэн (бичвэр, зурагт дүрслэлийн харьцааг тэнцвэртэй байлгах)
- Цаг үеийн агуулгыг хөндсөн (сэдэв ба арга зүйг ялгасан онцолбор)
- Давтлага, даалгавраар урам зоригийг нэмэгдүүлэх (жигд дасгал ажлаар урамшуулах)
- Асуудлыг шийдэх арга зүйгээр хангасан
- Бие даан сурах үйл ажиллагаанд чиглүүлсэн (танин мэдэх үйлийг нь нэмэгдүүлж бие даан суралцах чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэх). Жишээлэхэд франц хэлний сурах бичгийн зорилго нь суралцагчдад франц хэлийг эзэмшүүлэхэд л чиглэгдэнэ. Хэрхэн суралцах аргачлал буюу тухайн судлагдахууны агуулга, танин мэдэхүйн мөн чанарыг голлохгүй байх явдал юм.
- Суралцахуйн нэмэлт нөөцөөр хангах (тэгш үнэлэн дүгнэх). Мэдлэгийг гүнзгий эзэмшүүлэх үүднээс тогтмол үнэлж дүгнэх” (Jose Picardo)⁴ гэсэн үндсэн асуудлуудыг дэвшүүлсэн нь бий. Сурах бичгийн үнэлгээ нь багш, сурагчдад төдийгүй хэвлэлийн үйлдвэрийн цаашдын үйл ажиллагаанд онцгой нөлөөтэй зүйл юм. Үүнд: Багш төвтэй арга зүй, сурагч төвтэй арга зүй, багшийн сонголтыг харгалзан үзэх арга зүй зэргийг зүй зохистой сонгож хослуулан хэрэглэхээс гадна сурагчдын гүйцэтгэлийг үнэлэх, үнэлгээний төрлүүд, үнэлэмжийн арга зүйг оновчтой сонгох ажлыг эхлүүлэх шаардлага (Brown, Peter C. etc. 2014) нэхэгдэж байна.

Сурах бичиг нь гаднах үзэмж буюу өнгөн талдаа бат бөх хийцтэй, хавтас, хуудас бүрийн зохиомж бүхий зураг чимэглэл нь анхаарал татсан байхаас гадна дотоод агуулгын чанар хамгийн чухал үүрэгтэй. Тиймээс **агуулгын хувьд**:

1. Тухайн улсын стандарт төдийгүй, орон нутаг, тусгай боловсролын сургалтын агуулга, зорилтод нийцсэн байх
2. Сургалтын зорилго маш тодорхой, ойлгомжтой тодорхойлогдсон байх

⁴ <http://www.josepicardo.com/education/a-textbook-problem-seven-suggestions-to-improve-thequality-of-published-resources/> go

3. Суралцахуйн зорилт нь мэдлэгийн түвшнээс давсан байх
4. Агуулгын хүрээ болон дараалал нь тохирсон байх
5. Хүйсийн тэгш байдлыг харгалзсан хэл найруулгатай байх
6. Соёлын болон ямар нэг талыг үл барьсан ашиг сонирхлын бус хэл найруулгатай байх
7. Үндсэн сэдвүүд зүй зохистой цагийн хуваарилалтаар боловсруулагдсан байх
8. Шинэ үг хэллэг, нэр томъёоны тайлбар толь хавсаргаж өгөх
9. Зохиогчийн болон сэдвийн зүүлт тайлбар бэлтгэх
10. Хүснэгт, бүдүүвч, үзүүлэнт зураглал ойлгомжтойгоор дүрслэн тодорхойлогдох

Сургалт, арга зүйн хувьд:

1. Эх бичвэр нь хувь хүний болон хамт олны сурах үйл ажиллагаанд чиглэгдсэн байх
2. Сургалтын үргэлжлэх хугацаа буюу нэгж хичээлийн харьцаа зүй зохистой байх
3. Сэдвүүд нь өдөр тутмын амьдралтай холбоотой байх (хэт онолын бус)
4. Эх бичвэр нь мэргэжлийн судалгааны хэсгүүдээс бүрдэх
5. Эх бичвэр нь суралцагчдад урам түлхэц үзүүлсэн, ур чадварыг сорьсон байх
6. Нэгж хичээлүүд сайтар зохион байгуулагдсан байхын зэрэгцээ учир шалтгаант дарааллыг хадгалсан байна.

Хавсарга шинжлэх ухаан (технологи)-ы нэгдлийн хувьд:

1. Эх бичвэр дэх технологийн хэрэглээ, тусгай арга ашиглалтыг хамтатган нийлүүлэх
2. Цахим эх сурвалжуудыг нэгж хичээлтэй холбох
3. Загварчлалын хөтөлбөр (програм) хангамжийг нэмэгдүүлэх

Үнэлгээний аргачлалын хувьд:

1. Сурагчдад зориулсан зорилтот асуултуудыг бэлтгэх
2. Үнэлэх асуултуудыг хөтөлбөр хангамж, технологийн дэвшилтэй уялдуулах
3. Бататган үнэлэх асуултууд нь суралцахуйн зорилттой нягт уялдаатай байх
4. Үнэлгээний зорилго нь Блүүмийн системчлэлийн бүхий л түвшин буюу ялангуяа хэрэглээнд тулгуурлах

Багшийн гарын авлагын хувьд:

1. Хэрэглэхэд хялбар зааварчилгаатай байх
2. Багшийн мэдлэг, ур чадварыг шаардсан түвшинд бичигдэх
3. Цахим сурвалжуудыг зааж өгсөн байх
4. Жишээ загвар болсон хичээлүүдийг хавсаргах (уламжлалт болон төлөвлөлт)
5. Сурагчдад хичээлээс гадуурх ажил, төсөлт даалгавар санал болгох
6. Янз бүрийн заах арга барилыг дэвшүүлсэн (олон төрөлт сургалтын хэв маяг бүхий)
7. Багштай яаралтай холбогдох утасны дугаар болон цахим харилцааны хаяг, холбоосыг тэмдэглэх (хавсралтанд эх сурвалж бий Д.Ц) гэсэн үзүүлэлтээр 0-5 оноогоор үнэлэн дүгнэдэг (Arnold, David L. 1989) гэх мэт олон улсын жишиг, баримтлалуудыг туршин хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Тав. “Сурагчийн ном” буюу гарын авлага

Бидний бэлтгэсэн 2017 оны IX, 2018 оны VII, XII ангийн уран зохиолын сурах бичигт ардын аман зохиол, “Гэсэр”, “Жангар” зэрэг туульсийн бүтээл, “МНТ”, “Хөх судар” гэх мэт бичгийн сонгодог уран зохиол болон эртний сургаалийн шүлэг зохиолууд, орчин үеийн

дэлхийн (Шакундала, Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл, Харри Поттер) болон Монголын (Зугаацахаар мордсон нь, Дөрвөн цаг, Үер, Хөгшин чоно ульсан нь, Тунгалаг тамир, Оройгүй сүм, Тамгагүй төр) найраглал, тууж, роман, жүжиг зэрэг томоохон зохиолууд бүрэн эхээрээ ороогүй, дурдаад өнгөрсөн шинжтэй, бүр богино өгүүллэг ч бүтнээрээ багтахын аргагүй (Л.Өлзийтөгс “Аквариум” гэх мэт) болчихсон тул сурах бичигт нэмэлт хэрэглэгдэхүүн эрхгүй шаардагдаж байна. Өөрөөр хэлэхэд зарим ахлах ангид судалж буй шинжлэх ухааны салбараас үүтгэн “Сурагчийн ном” туршиж үзвэл ямар вэ гэсэн санал дэвшүүлье. Энэ нь багш, сурагчдын нэгдсэн зорилго, эх хэрэглэгдэхүүнийг хангах үндсэн гарын авлага болох сургалтын хөтөч буюу сурах бичгийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх юм. “Багшийн ном” - “Сурах бичиг” - “Сурагчийн ном” гэсэн урвуу хамаарал бүхий дараалалтай байх нь сургалтын чанарт эерэгээр нөлөөлж ахиц дэвшил үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Эх зохиолыг хичээлээс гадуур бүтнээр нь олж уншихад номын хүрэлцээ бага, хувийн хэвлэх үйлдвэрүүд зохиогчийн эрх авалгүй “хулгайн” аргаар хэвлэсэн байх тул үг үсэг, хэл найруулгын алдаа ихтэй, зарим хэсэг дутуу байдаг. Хэн хариуцаж ямар хэвлэлийн газар хэдэн хувь хэвлүүлсэн нь тодорхойгүй, редакторгүй (Ч.Лодойдамба. *Алтайд*. 2016 г.м) эх зохиол, ном, хэрэглэгдэхүүнүүд сурагчдын бие даан судалж унших сонирхол, сургалтын үр дүнд харин ч сөргөөр нөлөөлөхөөр байна. Нөгөө талаар улсын хэмжээний нийтийн номын сангууд Их, дээд сургуулийн оюутнуудын ачаалалд дарагдахын зэрэгцээ ЕБС-ийн сурагчдад шаардлагатай ном, эх хэрэглэгдэхүүний хүртээмж бага, хувь цөөн байдаг нь “эрэлт, нийүүлэлтийн зарчим”-ын хувьд дэндүү тэнцвэргүй үзүүлэлт билээ. Иймд хэсэг бүлэг хүмүүс, зарим багш нар “гарын авлага” нэртэй “гарааны бизнес” (эрдэмтэд, шинжлэх ухааны байгууллагуудад гарааны компани гэх ойлголт, ухагдахуун бийн адил) цэцэглүүлж хот, хөдөөгүй болсон болоогүй ном шахаж явдагийг цэгцлэх цаг нэгэнт тулжээ.

Зургаа. Судалгааны үр дүн:

Энэхүү өгүүлэлд монголын сургалтын хөтөлбөрийн биежилт болох боловсролын баримт бичиг буюу ЕБС-ийн сурах бичгийг дэлхийн буюу олон улсын түвшний сурах бичгийн шинэ хандлага, арга зүйтэй харьцуулан авч үзэхдээ ололт, туршлагыг орчуулан танилцуулж өөрийн санал, дүгнэлтийг дэвшүүлэн тодорхой үр дүнд хүрчээ.

Дүгнэлт

Сурах бичиг нь багшийн мэдлэг, заах арга зүй, сургалтын чанарын ахиц, боловсролын шинэчлэл гэх мэт олон тулгамдсан асуудалтай хамааралтай цогц ойлголт юм. Өмнөх нийгмийн тогтолцоонд хангалтгүй суралцагсдад боловсролын зэрэг бус “цагаан хуудас” өгч төгсгөдөг байсан шударга уламжлал эдүгээ тасарсан ч сурах бичгийн гүйцэтгэх үүрэг, түүнд тавигдах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймд салбар бүрийн сурах бичгүүд нийгэм, цаг үеийнхээ эрэлт, хэрэгцээнд нийцсэн байхын зэрэгцээ

1. Тогтсон нэр томъёо, мэргэжлийн үг хэллэг ашиглах шаардлагатай байна. Нийт сурах бичгүүдэд буй өөр ойлголт, ухагдахуун бүхий нэр томъёог цэгцлэх нь “Хойд”, “хушуу”, “хэншүү”, “эрвээхий”, “агуу” зэрэг үгсийг хэрхэн зөв бичиж стандартын түвшинд жигдлэхээс эхэлнэ. Тиймээс 2014 онд батлагдсан “Бага боловсролын цөм хөтөлбөр”, “Сурах бичиг хэвлэлийн стандарт”, “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага, стандарт” зэргийг мөрдлөгө болгон хэвшүүлэх нь зүйтэй юм.

2. Гадаад үгээс зайлсхийж эх хэлний дархлаа, бие даасан соёлыг хадгалах нь чухал хэвээр байна. “Мэдээлэл зүй”, “Математик”, “Физик”-ийн сурах бичгийн (програм хангамж /программ хангамж, (зүй нь хөтөлбөр хангамж) слайд, вирус, лого, дизайн гаргах) гэх мэт

үгсийг эх хэлнийхээ үгээр бүрэн төлөөлүүлж хэвших, хаалтанд тайлбар үйлдэх (чөлөөт программ хангамж, token тойрог, router /чиглүүлэгч гэх зэрэг) нь зүйд нийцнэ. Мөн “инфляци- үнийн өсөлт”, “фракц- бүлэг”, “редактор- хянан засварлагч” мэтийн орчуулах боломжтой, орчуулаад хэвшсэн үгүүдийг сонгох нь зүйтэй юм.

3. Хүүхдийн нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт тохирсон үг сонгож, ойлгомжтой хэл найруулгыг ашиглан үгийн утгыг тодорхойлон тайлбарлаж өгөх шаардлага бий. Сурах бичгийн агуулга, чанарыг сайжруулахын тулд олон дахин засварлах болдог. Засвар орох бүрд сурагчдын нас, сэтгэхүйгээс холдох буюу улам хүндэрч шинжлэх ухаанч тал нь илүү давамгайлдаг нь чанарын түвшиндээ урвуугаар нөлөөлөхөд хүргэдэг. Үүний улмаас түүхийн сурах бичгээс түүхийн шинжлэх ухаан руу, уран зохиолын сурах бичгээс утга зохиол судлал руу, монгол хэлний сурах бичгээс хэл шинжлэл рүү дөхсөн, тийм арга зүй рүү бүрэн шилжсэн шинжийг илтгэсээр байна. Мөн нэртэй, алдартай зохиолчдын улиг болсон (хүүхдийн сэтгэлгээ, цаг үеэс хоцрогдсон) зохиолуудыг сонгосноор зохиогчийн болон дүрийн хүйсийн тэнцвэрт байдал алдагддаг зэргийг анхаарууштай юм.

4. Зохиогчийн багийг чадварлаг гишүүдээр бүрдүүлэхийн зэрэгцээ нэг баг болон ажиллаж чадахуйц сэтгэлтэй, зуныхаа амралтыг зориулж чадах зүтгэлтэй, гадаад хэлний болон ерөнхий эрдмийн өргөн мэдлэгтэй, шинийг санаачлагч байх шаардлага эрхгүй дэвшигдэж байна. Сурах бичгийг зохиоход судалгаа шинжилгээнд үндэслэх шаардлагатай л юм бол мэргэжлийн эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэх, сургалтын эерэг үр дүнд хүрэх зорилт тавьж буй л юм бол идэвхитэй, эрдмийн зэрэг цолтой бус заах арга зүй сайтай, туршлагатай багш нартай хамтрах нь чухал байна.

5. Сурагчдын мэдлэгийг үнэлэх системийг боловсронгуй болгох цаг нэгэнт иржээ. Уламжилж тогтсон үсэг, тоогоор бус үзүүлэлт бүрээр буюу хичээлийн идэвхи, оролцоо, гүйцэтгэл зэргийг цогцод нь үнэлэх шинэ систем нь “Эрдэнэ бол сайн сурагч” гэсэн ерөнхий үнэлэмж, багшийн үзэмжээр бус тодорхой үндэслэлтэй, суралцагсдын идэвхи, сонирхлыг өрнүүлэх, мэдлэгийн явцыг зөв тогтоох уян хатан шалгуур бүхий шинэ шаардлага үүтгэгдэж байна.

6. Сурах бичгийг хэвлэн түгээхээс нэг жилийн өмнөөс дадлагын баг ажиллуулан сургалтын хөтөлбөр, агуулгыг туршин бататгахын зэрэгцээ шинэ түвшинд зохион бичих хугацааг нэмэгдүүлж өгөх нь зүйтэй байна. Учир нь өнөө цагийн сурах бичиг нь ухаалаг төхөөрөмжөөс дутахгүй сонирхолтой, уншихгүй байхын аргагүй өвөрмөц, нэмэлт мэдээлийн сан, нөөцтэй, чансаатай байх хэрэгцээг мөн зайлшгүй шаардаж байна.

7. Дэлхий нийтийн ЕБС-ийн сурах бичгийн ололт- шинэчлэл, бүтээлч санаачлагуудыг мөрдлөгө болгож, сурах бичигт тавигдах олон улсын шаардлага, хэмжүүрийг судлан туршихын зэрэгцээ шинэ хандлага, арга зүй, ахисан түвшний уялдаа холбоо зэргийг үндэстний онцлог, монгол хүүхдийн нас, сэтгэхүйн ялгамжид тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай, үндэслэл-судалгаатай хэрэгжүүлэх цаг үеийн шаардлага дэвшигдэж байна.

Abstract

In this article suggested that some new idea to improve textbooks quality of Mongolian educational system. For example, training team (teacher's book - textbook - pupil's book) or comprehensive teaching aid and wall charts because of discovered some grammar and other mistakes by content, instructional properties, technology integration, teachers guide, assessment properties and other genres. In vocabulary, to choose an appropriate word a child's age and psychology, use an official terms and terminology and avoid foreign words by certain writing skills in textbooks of high schools. Technical editors should choose from the linguistics, and general editors should be specilized and skillful writers. When editing many times that textbooks becoming

more difficult to the learners. According to authors should be deep knowledge and an innovative with foreign languages. Also, to introduce a new teaching method and should know an ISD, Kemp models, Bloom's taxonomy and other international methods or evaluation criteria for textbooks.

Ном зүй

- Ben-Ari, M., Walker, H. M., Redvers-Mutton, G., Mansfield, K.** *Writing a textbook.* Proceedings of the 7th Annual Conference on innovation and technology. New-York. 2002.
- Brown, Peter C., Henry L. Roediger, Mark A., McDaniel.** *Make It Stick: The Science of Successful Learning.* 2014.
- Hatch, Mary Jo.** *Writing from Teaching: A Textbook Writer's Tale.* Journal of Management Education. 2007, Vol. 31, no. 3, pp. 405-412.
- Jackson S. A.** *About publishers, teachers, and reading achievement.* The textbook in American society. 1981, pp. 9-11.
- Jones, Alan.** *Conceptual Development in Technical and Textbook Writing: A Challenge for L1 and L2 Student Readers.* Proceedings of the International Professional Communication Conference. Limerick, Ireland. 12-15 July, 2005.
- Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага, стандарт. MNS 5418:2008. Уб., 2008.
- Батчулуун Е. нар.** *Хүн ба орчин-II.* Уб., 2018.
- Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр.* Уб., 2017.
- Бямбацэрэн Г. нар.** *Монгол хэл-II.* Уб., 2018.
- Отгонцэцэг А.** *Ерөнхий боловсролын сурах бичгийн чанар, хүрэлцээ, хангамжийн байдал.* Уб., 2012.
- Туяа У. нар.** *Иргэний боловсрол-II (Ёс суртахууны унших эх).* Уб., 2016.
- Цэдэн-Иш Д. нар.** *Дүрслэх урлаг, технологи-II.* Уб., 2017.
- Цэндсүрэн Ө. нар.** *Монгол хэл-III.* (Гурав дахь хэвлэл). Уб., 2016.
- Энхжаргал С., Боролзой Д.** *Эх хэлний боловсролын асуудалд.* Уб., 2017.
- Эрдэнэчимэг Б., Энхчимэг Д.** *Математик-III.* (тав дахь хэвлэл). Уб., 2018.

Цахим сурвалж

- <https://www.edb.gov.hk/en/curriculum-development/resource-support/textbook-info/SelectionCriteria.html>.
- <http://oaji.net/articles/2017/1330-1507024757.pdf>
- http://edutechwiki.unige.ch/en/First_principles_of_instruction <https://en.oxforddictionaries.com/definition/textbook>.
- https://www.rhineland.k12.wi.us/cms_files/resources/TextbookSelection.pdf
- https://www.superduperinc.com/handouts/pdf/149_VocabularyDevelopment.pdf
- <http://www.josepicardo.com/education/a-textbook-problem-seven-suggestions-to-improve-the-quality-of-published-resources/>.
- http://edutechwiki.unige.ch/en/First_principles_of_instruction go
- https://www.rhineland.k12.wi.us/cms_files/resources/TextbookSelection.pdf
- <http://www.josepicardo.com/education/a-textbook-problem-seven-suggestions-to-improve-the-quality-of-published-resources/>

Хавсралт

CRITERIA FOR TEXTBOOK EVALUATION

General Information:

Publisher: _____

Name of text: _____

Author(s): _____

Date of Publication: _____ Edition (year): _____

ISBN # _____ Cost _____

Using a 0 to 5 rating scale, with 5 being high (Excellent) and 0 being low (Poor), please rate the following statements concerning the text being evaluated. Physical Properties: _____ Durability _____ Attractive (cover, page layout, etc.) Content: _____ Content matches state standards and local curriculum _____ Instructional objectives are clearly stated _____ Objectives go beyond the knowledge level. _____ Scope and sequence are appropriate _____ Uses gender neutral language _____ Uses culturally unbiased language _____ Major topics are treated appropriately time-wise _____ Glossary of Terms or formulas is provided _____ An Index by topic/author is provided. _____ Tables, charts and diagrams are clearly illustrated and described. Instructional Properties: Page 1 _____ Text lends itself to individual or group instructional strategies _____ Length of instructional units is appropriate _____ Topics include links to everyday life (relevancy) _____ Text provides sections on vocational exploration _____ Text provides thought-provoking and challenging activities for students. _____ Units are well organized and arranged logically. Technology Integration: _____ The use of technology is integrated within the text. _____ Internet resources are integrated into units. _____ Simulation software is provided. Assessment Properties: _____ Study questions are provided for students. _____ A software bank of assessment questions is provided. _____ Assessment questions are related to the instructional objectives. _____ Assessments address all levels of Bloom's Taxonomy, especially application. Teachers Guide: _____ Guide is easy to use. _____ Teacher resources are provided. _____ Internet resources are provided. _____ Sample lessons are provided (traditional & block schedules) _____ Suggested student projects are provided. _____ Suggested teaching strategies are provided (for different learning styles). _____ Teacher hotline, phone or web assistance is provided⁵.

⁵ https://www.rhineland.k12.wi.us/cms_files/resources/TextbookSelection.pdf